



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС

2023 оны 11 сарын 28 өдөр

Дугаар 302

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 28 дугаар хуралдааны тэмдэглэлд:

ХХҮИИ.32.ХЭЛЭЛЦСЭН нь:

“Төв авто замын засвар арчлалт” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгийг орон нутгийн өмчид шилжүүлэх тухай.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

“Төв авто замын засвар арчлалт” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 66,004,166.71 (жаран зургаан сая дөрвөн мянга нэг зуун жаран зургаан төгрөг далан нэгэн мөнгө) төгрөгийн балансын үнэ, 8,324,849.00 (найман сая гурван зуун хорин дөрвөн мянга найман зуун дөчин ес) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 3 дугаар багийн нутаг Найрамдал хотхоны 11 дүгээр байрны 1 дүгээр орцны 15 айлын орон сууцыг Говьсүмбэр аймгийн өмчид шилжүүлэх асуудлыг дэмжээд, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу Засгийн газар, Улсын Их Хуралд тавьж шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж үзэв.

Хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн төрийн өмчөөс орон нутгийн өмчлөлд эд хөрөнгө шилжүүлэх шийдвэр гарах хүртэл хугацаанд хариуцан ажиллахыг Говьсүмбэр аймгийн Засаг дарга (Г.Батсуурь) -д зөвшөөрөв” гэжээ.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



132320097

28-r_huraldaan.docx